

“ХӨХ ГАН” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2020 оны 04 сарын 30 өдөр

Улаанбаатар хот

“Хөх ган” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2020 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр Би Ди Сек ҮЦК ХК-ийн төв байрны 6 давхар тоотод 14:00 цагт эхлэв.

Тооллогын комиссын ирцийн тогтоолоор хурлын ирц 84.09%-иар хүчин төгөлдөр болов.

Хурлын дарга: Хурлыг нээж компанийн 2019 оны үйл ажиллагааны тайлан, санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт болон 2020 оны төлөвлөгөөг 2020 оны зардлын тосов танилцуулав.

Хурлын дарга Д.Мөнхбазар: 2020.04.30-ны хурлыг давагдашгүй хүчин зүйлийн улмаас COVID-19 дэлхий даяар гараад байгаа цар тахал өвчиний шалтгаанаас болж Хувьцаа эзэмшигчдийн хурлыг онлайн хурлаар зохион байгуулж байна. Дараах 5-н асуудлаар хурал явагдана. Хурлын ирцийг тооллогын комиссын дарга С.Алтанцэцэг хурлын дэг танилцуулна. Хурлын ирц 84.09% ирц бүрэн хурлыг эхлэв.

ТУЗ-н нарын бичгийн дарга Н.Цэцэгдэмбэрэл гишүүдийн танилцуулга хийнэ.

ТУЗ-н нарийн бичгийн дарга Н.Цэцэгдэмбэрэл: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргье. ТУЗ-н гишүүн Ц.Батболд, ХЭХ-н даргаар Д.Мөнхбазар, ХЭХ-н тооллогын гишүүнээр ерөнхий инженер Л.Бямбадорж, Тооллогын комиссын даргаар С.Алтанцэцэг нар оролцож байна.

Хурлын дарга Д.Мөнхбазар: 1. 2019 оны үйл ажиллагааны санхүүгийн тайлан болон хараат бус аудитын дүгнэлт, ТУЗ-н гишүүдийн танилцуулга, 2020 оны зардлын төсвийг ерөнхий нягтлан бодогч Н.Цэцэгдэмбэрэл. 2. 2019 оны үйл ажиллагааны тайлан 2020 оны төлөвлөгөөг ХЭХ-н дарга Д.Мөнхбазар 3. 2019 болон 2020 оны төлөвлөгөө танилцуулгыг ХЭХ-н тооллогын гишүүн Л.Бямбадорж нар тус тус танилцуулна.

ХЭХ-н тооллогын гишүүн Л.Бямбадорж: 2008 онд Монголын хөрөнгийн бирж дээр хувьцаагаа гарган өнөөдрийн хэмжээнд 900 гаруй хувьцаа эзэмшигчидтэй. Тус үйлдвэрийг барьж байгуулсан 2009 онд Үйлдвэрийн эхний шугамыг ашиглалтанд оруулж, Монгол улсад анхны Ангжруулсан төмрийг үйлдвэрлэсэн юм. Энэхүү ангижруулсан төмрийг хайлуулан арматур, ган бэлдэц гаргаснаар Монгол улс өөрийн орны төмрийн хүдрээс шат дараалан боловсруулж эцсийн бүтээгдэхүүн анх удаа гаргасан.

2010 онд Монгол улсын Засгийн газар, МҮХАҮТ-аас хамтран зохион байгуулсан “Монголд үйлдвэрлэв- 2009” үзэсгэлэнд Шууд ангижруулсан төмөр бүтээгдэхүүнээрээ оролцож, үзэсгэлэнгийн Гран-при шагналыг авсан юм.

Манай компанийн үйлдвэрлэдэг шууд ангижруулсан төмөр нь хаягдал төмөр, ширмийг бүрэн орлох ба чанар, үр ашгийн хувьд илүү, сайн чанарын ган үйлдвэрлэхэд үндсэн түүхий эдээр хэрэглэдэг. Тус үйлдвэр нь жилдээ 40 мян.тонн төмрийн хүдрийн баяжмал боловсруулж, 30 мян.тонн 84-92% төмрийн агуулгатай ШУУД АНГИЖРУУЛСАН ТӨМӨР үйлдвэрлэх хүчин чадалтай дан ганц шууд ангижруулсан төмөр үйлдвэрлэдэг чиглэлээр биш компанийн ашиг борлуулалтын ашиг орлоготой болгох үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэх нэмэлтээр төрөлөө нэмэгдүүлэх арга технологио өрөгжүүлж ажилласан. Монгол улсын хувьд анхны төмрийн баяжмалыг боловсруулж буй металл төмөр үйлдвэрлэгч үйлдвэр юм. Тус компани нь БНХАУ-н металлургийн тэргүүлэх компаниудтай хамтран ажилладаг бөгөөд өөрийн улсаас авах боломжгүй түүхий эд материалыг дээрх компаниудаас импортлон авдаг юм.

Хурлын дарга Д.Мөнхбазар: 2019 онд бид бүхэн үйлдвэрийн барилга, тоног төхөөрөмж засвар шинэчлэлт нилээн хийгдсэн. Бид бүхэн ТУЗ-д болон хувьцаа эзэмшигч та бүхэнд

тараах материал дээрээ дэлгэрэнгүй имэйл хаягаар өгсөн байгаа ингээд та бүхэнд товч танилцуулья.

1.Үйлдвэрийн хүрээнд хийгдсэн ажлууд 2-4-р улиралд бороо усны хаялага, засваруудыг нилээн түлхүү хийсэн. 2. Туннель зуухны тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ сэлбэг материалыг 2-4 –р улиралд нилээн шахуу хийгдсэн. 3. 1 болон 2-р хийн зуухны засвар үйлчилгээ тоног төхөөрөмжийн сэлбэгүүдийг 3-р улиралд хийгдсэн. 4.Оффисын барилгад дотор болон гадна засал агуулах бараа материалыг эмхэлж цэгцэлсэн. 5. Цахилгаан хангамжийн мантажийг үйлдвэр болон оффис нийтээр нь засаж шинэчилсэн, өндөр хүчдэлийн дэд станц, ХТП-318-уудын тоноглолууд материалыг 3-р улиралд багтаан хийсэн. 6. Ус , дулаан хангамжийн хүрээнд 320м2 шугамын ажил сольсон. 7. Хог хаягдлын цэвэрлэгээ ,хур хог зайлуулах ажилыг нэлээн түлхүү хийсэн. 8.Үйлдвэрийн ажиллагсдын сургалт ,бүртгэлийн ажлууд хийгдсэн. 2018 оноос 2019 оны засвар үйлчилгээний ажилуудыг Бэрэн металл ХХК-с санхүүжигдаж , инженер техникийн ажилтануудаар засварын ажлыг удирдуулан хийгдсэн. Нийт санхүүжилтын дүнгэ танилцуулж байна.

№	Барааны нэр	2018 оны төсөв Дүн сая төгрөг	2018 оны гүйцэтгэл Дүн сая төгрөг	2019 оны гүйцэтгэл Дүн сая төгрөг	2018-2019 оны нийт гүйцэтгэл Дүн сая төгрөг
1	Барилга	195.1	192.9	221.5	414.4
2	Хог хаягдал, цэвэрлэгээ /БМ хураалт/	36.1	6.6	97.0	103.6
3	Машин тоног тохооромж	212.3	14.4	246.6	261.0
4	Бусад байгууламж			69.2	69.2
	дүн	443.6	213.9	634.3	848.2

2020 оны төлөвлөгөө:

- Үйлдвэртэй холбоотой бичиг баримт бүрдүүлэх .
- Дамжлагуудад ашиглагдаж байгаа гар ажиллагааг механикжуулах,автоматуулалт хийх.
- Ажлийн зохион байгуулалтыг сайжруулж, хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлэх
- Технологийн горим, үйлдвэрлэл
- Тоног төхөөрөмжийн ашиглалтыг сайжруулах замаар сул зогсолтыг багасгах
- Барилга байгууламжийн засвар, арчилалт
- Судалгаа туошилтын ажлуудын чиглэл
- Бүтээгдэхүүн, түүхий эдийн чанар,дамжлагын хяналт
- Талбайн зохион байгуулалтын ажил
- Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаатай холбоотой ажлууд хийгдэнэ

ТУЗ-н нарийн бичгийн дарга Н.Цэцэгдэмбэрэл: Хөх Ган ХК Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Аудитын хороо нь Компанийн тухай хуулийн 81.4 дүгээр зүйлийн дагуу үйл ажиллагаа явуулсан бөгөөд Хөх Ган ХК-ий санхүүгийн тайланд 2019 оны 12-р сарын 31-ий байдлаар аудит хийж дүгнэлт гаргалаа. Хөх Ган ХК нь 2019 оны 12 дугаар сарын 31-ий өдрөөр дуусгавар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан болон үр дүн, мөнгөн гүйлгээний тайланг Санхүүгийн Тайлагналын Олон улсын Стандарт болон Монгол улсад мөрдөж байгаа

холбогдох заавар, журмын дагуу үнээ зөв толиллуулан бэлтгэгдсэн байна. Хөх Ган ХК нь хараат бус аудиторын тайланг ЮНИСТАР-Аудитын компаниар 2019 оны санхүүгийн үйл ажиллагаанд аудит хийлгэжээ. 2019 оны байдлаар их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй гэрээ, хэлцэл хийгдээгүй гэж үзэв. НББ-ийн бодлогын баримт бичгийг боловсруулж, санхүүгийн тайланд илэрхийлэгдсэн авлага, өглөгийн дэлгэрэнгүй бүртгэл, тайлан журналыг тогтмол хөтөлж, тооцоо хийсэн актаар баталгаажуулсан байна. Санхүүгийн тайлангийн ерөнхий удирдлагын зардлыг танилцуулахад ажилчидын цалинд 36.3 сая төгрөг, НДШ-н зардалд 4.5 сая төгрөг, албан томилтын зардалд 430.0 мянган төгрөг, ХЭХурлын зардалд 2 сая төгрөг, ТЭЗҮ-н зардалд 8.1 сая төгрөг, БОНУ-н ТЭЗҮ-н зардалд 2 сая төгрөг, ХЭАБ-н сургалтын зардалд 550.0 мянган төгрөг, бусад зардалд 850 мянган төгрөг, хандив тусламжийн зардалд 9.8 сая төгрөг тус тус зарцуулсан байна.

2020 оны зардлын төсөв танилцуулахад нийт 64.5 сая төгрөгийн зардалтай үүнээс ТУЗ-н гишүүд болон ТУЗ-н нарын бичгийн цалингийн зардалд 1 жилд 50.4 сая төгрөг 1 сарын дундаж цалин нь 420 мянган төгрөг байхаар байна. МХБ-н бүртгэлийн хураамж 1.2 сая төгрөг, зөвлөх үйлчилгээний хураамж 1.5 сая төгрөг, аудитын төлбөр 2.2 сая төгрөг, MTV –н нэвтрүүлгийн хураамж 8 сая төгрөг, ХЭХ-н зардалд 600 мянган төгрөг тус тус зарцуулахаар байна.

ТУЗ-н гишүүд болон хараат бус гишүүдийн танилцуулга:

1. “Хөх Ган” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн гишүүдээр:

1. Б.Мөнхтөр
2. Ц.Батболд
3. Д.Даянбилгүүн
4. Б.Лхагвадорж
5. Г.Энхболд
6. Ц.Батбаяр
7.

Хараат бус гишүүдээр:

1. Д.Энхбат
2. Д.Чинбат
3. Х.Батхишиг
4. Б.Алтансүвд нарыг тус тус нэр дэвшүүлсэн байна.

Үүний дараагаар тооллогын комиссын гишүүн саналын хуудас бөглөх зааврыг танилцуулав санал хураах үйл ажиллагаа эхлэв.

Тооллогын комиссын дүн:

Хурлаар дараах асуудлуудыг ердийн аргаар санал хураан шийдвэрлэв.

1. Саналын хуудсаар “Хөх Ган” ХК-ийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж

батлах асуудлаар хуралд оролцож байгаа саналын эрхтэй нийт хувьцаа эзэмшигчдийн 62.5648% зөвшөөрсөн, 0 % татгалзсан, 37.4352 % түдгэлзсэн байна.

Зөвшөөрсөн		Татгалзсан		Түдгэлзсэн	
Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	хувь
53,301,914	62.5648%	0	0%	31,892,837	37.4352%

2. Саналын хуудсаар “Хөх Ган” ХК-ийн 2019 оны санхүүгийн тайланд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлтийг батлах асуудлаар хуралд оролцож байгаа саналын эрхтэй нийт хувьцаа эзэмшигчдийн 62.5648% зөвшөөрсөн, 0 % татгалзсан, 37.4352 % түдгэлзсэн байна.

Зөвшөөрсөн		Татгалзсан		Түдгэлзсэн	
Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	хувь
53,301,914	62.5648%	0	0%	31,892,837	37.4352%

3. Саналын хуудсаар “Хөх Ган” ХК-ийн 2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах асуудлаар хуралд оролцож байгаа саналын эрхтэй нийт хувьцаа эзэмшигчдийн 62.5648% зөвшөөрсөн, 0 % татгалзсан, 37.4352 % түдгэлзсэн байна.

Зөвшөөрсөн		Татгалзсан		Түдгэлзсэн	
Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	хувь
53,301,914	62.5648%	0	0%	31,892,837	37.4352%

4. Саналын хуудсаар “Хөх Ган” ХК-ийн ТУЗ-ийн 2020 оны зардлын төслийг батлах тухай асуудлаар хуралд оролцож байгаа саналын эрхтэй нийт хувьцаа эзэмшигчдийн 100% зөвшөөрсөн, 0 % татгалзсан, 0 % түдгэлзсэн байна.

5.

Зөвшөөрсөн		Татгалзсан		Түдгэлзсэн	
Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	хувь
85,194,751	100%	0	0%	0	0%

6. Саналын хуудсаар “Хөх Ган” ХК –ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг кумулятив аргаар сонгох тухай асуудлаар хуралд оролцож байгаа саналын эрхтэй нийт хувьцаа эзэмшигчдийн өгсөн саналын дүн.

А. Ердийн гишүүнд өгсөн санал:

№	ТУЗ-ийн ердийн гишүүнд нэр дэвшигчдийн нэрс	Кумулятив аргаар өгсөн саналын тоо	Хувь
1	Б.Мөнхтөр	79,915,791	15.6339%
2	Ц.Батбаяр	79,915,791	15.6339%
3	Ц.Батболд	79,915,791	15.6339%

4	Д.Даянбилгүүн	95,752,731	18.7321%
5	Г.Энхболд	79,915,791	15.6339%
6	Б.Лхагвадорж	95,752,731	18.7321%

Тус тус санал авч дараах гишүүд ердийн гишүүнд сонгогдов.

1. Б.Мөнхтөр
2. Ц.Батбаяр
3. Ц.Батболд
4. Б.Лхагвадорж
5. Д.Даянбилгүүн
6. Г.Энхболд

Б.Хараат бус гишүүнд өгсөн санал:

№	ТУЗ-ийн хараат бус гишүүнд нэр дэвшигчдийн нэрс	Кумулятив аргаар өгсөн саналын тоо	Хувь
1	Б.Алтансүвд	50,834,220	19.8894%
2	Д.Энхбат	79,915,791	31.2679%
3	Д.Чинбат	79,841,591	31.2388%
4	Х.Батхишиг	44,992,711	17.6039%

Тус тус санал авч дараах гишүүд хараат бус гишүүнээр сонгогдов.


1. Д.Энхбат
2. Д.Чинбат
3. Б.Алтансүвд

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын дүнг Тооллогын комисс дэгийн дагуу танилцуулав.

Хувьцаа эзэмшигчдийн ирцийн бүртгэл, саналын хуудас, Тооллогын комиссын тогтоол №1,2-ийг тус тус тэмдэглэлд хавсаргав.

Хурлын дарга хурал хаах үг хэлснээр хурал 15:55-т дуусав.

Хурлын дарга:


/Д.Мөнхбазар/

Тэмдэглэл хөтөлсөн:

 / Н.Цэцэгдэмбэрэл /